

**Аймгийн нийгэм эдийн засгийн  
12-р сарын танилцуулга**

Нийгмийн үзүүлэлт:

- I. Ажлын байрны зуучлал
- II. Бүртгэлтэй ажилгүйчүүд
- III. Нийгмийн халамж
- IV. Нийгмийн даатгал
- V. Эрүүл мэнд
- VI. Боловсрол
- VII. Гэмт хэрэг
- VIII. Гамшиг, осол, гал түймрийн мэдээ

Эдийн засгийн үзүүлэлт:

- IX. Төсвийн орлого
- X. Төсвийн зарлага
- XI. Банк
- XII. Үнэ
- XIII. Хөдөө аж ахуй
- XIV. Аж үйлдвэр

## Хавсралт хүснэгтүүд

- I. Ажлын байрны зуучлал
- II. Аймгийн ажил хайгч иргэдийн мэдээлэл
- III. Нийгмийн халамжийн сангийн мэдээ
- IV. Нийгмийн зарим үзүүлэлтүүд
- V. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага
- VI. Нийгмийн даатгал заавал даатгуулагчийн тоо, тэтгэврийн хэмжээ
- VII. Эрүүл мэндийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд
- VIII. Хүн амын ердийн хөдөлгөөн, хүүхдийн эндэгдэл
- IX. Гэмт хэргийн мэдээ
- X. Гамшиг, осол, гал түймрийн мэдээ
- XI. Орон нутгийн төсвийн орлогын мэдээлэл
- XII. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт /Сумаар/
- XIII. Орон нутгийн төсвийн зарлагын дүн
- XIV. Дундговь аймаг дахь банкны салбарын мэдээлэл
- XV. Хэрэглээний үнийн индекс
- XVI. Гол нэрийн бүтээгдэхүүний үнэ
- XVII. ХАА-н бүтээгдэхүүний үнийн мэдээ
- XVIII. Төл бойжилтын мэдээ
- XIX. Тариалсан талбай, хураасан ургацын мэдээ
- XX. Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн
- XXI. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

# Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2020 оны 12-р сарын байдлаар)

## Нийгмийн үзүүлэлт

### I. Ажлын байрны зуучлал



ХХҮГазрын мэдээгээр 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 575 хүн ажлын байранд зуучлагдсан нь өмнөх оны мөн үеэс 37 хүнээр буурсан байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд ХАА, ан агнуур, ойн аж ахуйн салбарт 10.5 хувь, боловсруулах үйлдвэрт 1.6 хувь, цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт 0.3 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт 4.3 хувь, боловсролын салбарт 7.3 хувь, үйлчилгээний бусад салбарт 41.6 хувь, хүний эрүүл мэнд нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт 3.5 хувь, төрийн удирдлага ба батлах хамгаалах үйл ажиллагааны салбарт 8.3 хувь, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт 1.0 хувь, урлаг, үзвэр, тоглоом наадмын салбарт 1.6 хувь, санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбарт 1.6 хувь, бөөний ба жижиглэнгийн худалдааны салбарт 1.7 хувь нь зуучлагдсан байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийн 294 нь буюу 51.1 хувь нь эмэгтэйчүүд байна.

### II. Бүртгэлтэй ажилгүйчүүд



2020 оны жилийн эцсийн байдлаар аймгийн ХХҮГ-т бүртгэлтэй, ажил хайж байгаа 524 хүн бүртгэгдсэн нь өмнөх сартай харьцуулахад 3 дахин өссөн байна. Нийт ажилгүйчүүдийн 48.1 хувь буюу 252 хүн нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 162 ажил хайгч иргэн ногдож байхад Хулд 312, Говь-Угтаал 479, Дэлгэрхангай 247, Баянжаргалан 186 байгаа нь аймгийн дунджаас дээгүүр байна.

### III. Нийгмийн халамж



2020 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн халамжийн сангаас 20022 хүнд 7 027.0 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, халамжийг олгосон байна. Нийт тэтгэвэр тэтгэмж авагчдын 13.8 хувь буюу 0-3 насны хүүхдээ асарч буй 2761 эхчүүдэд 110.7 сая төгрөг, 5.7 хувь буюу 1167

жирэмсэн эмэгтэйчүүдэд 17.2 сая төгрөг, 11.2 хувь буюу 2242 иргэнд нийгмийн халамжийн тэтгэмж 1 827.7 сая төгрөг, 4.2 хувь буюу 837 иргэнд халамжийн тэтгэвэр 2 542.0 сая төгрөг, 23.1 хувь буюу 4 622 иргэнд алдарт эхийн одонгийн мөнгөн тусламж 616.7 сая төгрөг, 13.2 хувь буюу 2634 иргэнд насны хишигт 459.4 сая төгрөг, 15.0 хувь буюу 2996 иргэнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлж, 682.3 сая төгрөгийг зарцуулжээ.

#### **IV. Нийгмийн даатгал**



Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны жилийн эцсийн байдлаар 43 165.2 сая төгрөг, зарлага 40 505.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 8 308.9 сая төгрөгөөр буюу 23.8 хувиар, зарлага 6 432.8 сая төгрөг буюу 18.8 хувиар тус тус өсчээ.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалд 2020 оны 12 сарын байдлаар 11920 хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 2396 хүн буюу 20.1 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагаас, 4199 хүн буюу 35.2 хувь нь төсөвт байгууллагаас, 5325 хүн буюу 44.7 хувь нь сайн дураар шимтгэл төлсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад сайн дурын даатгуулагч, аж ахуй нэгж байгууллага өсч, төсөвт байгууллагын даатгуулагч буурсан байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2020 оны 12 сарын байдлаар 34 885.8 сая төг болж, үүний 84.5 хувийг өндөр настны, 9.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 2.6 хувийг тэжээгчээ алдсаны, 3.1 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна.

Мөн тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч хүн 7749 байна. Нийт тэтгэвэр авагчдын 83.7 хувь буюу 6487 хүн өндөр насны, 11.3 хувь буюу 877 хүн тахир дутуугийн, 3.1 хувь буюу 241 хүн тэжээгчээ алдсаны, 1.9 хувь буюу 144 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна.

Энэ оны 12 сарын байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 2370, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчид 27, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагч 191 хүн байна. Мөн эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоо 13778 байгаагийн 60.5 хувь буюу 8353 төр хариуцах иргэд, 26.7 хувь буюу 3682 малчид, 3.7 хувь

буюу 510 оюутан суралцагсад, 9.1 хувь нь буюу 1250 аж ахуй нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн байна.

2020 оны жилийн эцэст аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 12 038.7 сая төгрөг болж төлөвлөгөө 1.5 хувиар буюу 183.6 сая төгрөгөөр давж биелсэн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө бүх сумд 0.6–5.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

## V. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар 889 эх төрсөн ба нийт 896 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 54 төрөлтөөр буурсан байна. Төрсөн эхчүүдийн 90.2 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт энэ сарын байдлаар 0-5 насны хүүхдийн 9 эндэгдэл гарсан байна. Нас баралтын 233 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 23 тохиолдлоор буурчээ. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт 58 буюу 24.9 хувийг эзэлж байна.

Тухайн сарын байдлаар стационарит шинээр 10061 эмчлүүлэгч хэвтэж, 10144 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 69334 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 6.8 байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар 183866 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 29.7%, өвчний учир амбулаторийн үзлэг 49.6%, идэвхтэй хяналт 15.4%, гэрийн идэвхтэй үзлэг 3.9 %, гэрийн дуудлагын үзлэг 1.4%- ийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 34.2 хувь нь эрэгтэй, 65.8 хувь нь эмэгтэй хүн байна. Халдварт өвчний 308 тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 66.1 хувь болж өмнөх оны мөн үеэс 99 тохиолдол буюу 21.2 пунктээр буурсан байна.

## VI. Боловсрол



2020-2021 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 19 сургуульд 8457 суралцагчид сурч байгаагийн 49.7 хувь буюу 4205 нь эмэгтэй сурагчид байна. Өмнөх оны мөн үеэс сурагчдын тоо 0.3 хувь буюу 23 хүүхдээр өсчээ. Энэ хичээлийн жилд 1-р ангид 895 сурагч элсэн орсон нь

өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад 3.9 хувиар буурсан байна. 2020-2021 оны хичээлийн жилд 22 цэцэрлэгт 2923 хүүхэд хүмүүжиж, цэцэрлэгт хамрагдалт 67.3 хувь байна.

## VII. Гэмт хэрэг




Дундговь аймаг дахь Цагдаагийн газар нь 2020 оны жилийн эцэст иргэн, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 1571 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 301 гомдол, мэдээллээр буюу 16.1 хувиар хүлээн авсан гомдол, мэдээллийн тоо буурсан байна.

2020 онд улсын хэмжээнд 23064 гэмт хэрэг бүртгэгдсэний 196 буюу 0.8 хувийг, орон нутагт нийт 8420 гэмт хэрэг бүртгэгдсэний 2.3 хувийг Дундговь аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг эзэлж, өмнөх оны мөн үеэс 15 хэргээр буюу 7.1 хувиар гэмт хэргийн гаралт буурсан байна.

Нийт гэмт хэргийн гаралт буурахад, хулгайлах гэмт хэрэг 12.3 хувь, мал хулгайлах гэмт хэрэг 37.9 хувь, залилах гэмт хэрэг 7.2 хувь, хүчиндэх гэмт хэрэг 40 хувь, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 7.2 хувиар тус тус буурсан нь шууд нөлөөлсөн байна.

Гэмт хэргийн гаралтыг төвийн бүсийн ойролцоо аймгуудтай харьцуулан графикаар харуулахад :



Гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 692.9 сая төгрөгийн хохирлын 257.1 сая төгрөгийн хохирлыг мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлж, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт 37.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4 пунктээр өссөн.

Тайлангийн хугацаанд 55 сая төгрөгийн эд хөрөнгө битүүмжилсэн байна.

Гэмт хэргийн улмаас 201 иргэн хохирч, 8 хүн нас барж, 83 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй ижил байна.

Гэмт хэрэгт нийт 149 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19 холбогдогчоор буюу 14.6 хувь өссөн.

Гэмт хэргийн илрүүлэлтийн түвшин улсын хэмжээнд 51.9 хувьтай, Дундговь аймагт 62.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс улсын түвшин 7 хувиар, аймгийн түвшин 5.4 хувиар өссөн үзүүлэлт байна. Гэмт хэргийн илрүүлэлт улсын дунджаас 6.8 пунктээр өндөр байна.

Нийт гэмт хэргийн 55 буюу 28.1 хувь нь согтуугаар, 12 буюу 6.2 хувь нь эмэгтэй хүн оролцсон, 14 буюу 7.2 хувь нь бүлэглэн гүйцэтгэсэн, 8 буюу 4.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны 12 сарын байдлаар 17623 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үеэс 3968 зөрчлөөр буюу 18.4 хувиар, 17619 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3989 зөрчлөөр буюу 18.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зөрчил гаргасан 17299 иргэнийг 533.0 мянган төгрөгөөр торгосон байна. Үүнээс тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэргээр 225 хүнийг торгон, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж, 93 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.

Нийт 430 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 302 хүн буюу 41.2 хувиар буурсан байна.


## **VIII. Гамшиг осол, гал түймрийн мэдээ**



Аймгийн Онцгой байдлын газрын мэдээгээр 2020 оны 12 дугаар сарын байдлаар аюулт үзэгдэл, ослын мэдээгүй. Объектийн гал түймрийн дуудлага бүртгэгдээгүй байгаа нь коронавирус /ковид-19/-ийн дэгдэлт нэмэгдэж бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдон иргэд гэртээ байгаатай холбоотой байх магадлалтай юм.

## Эдийн засгийн үзүүлэлт


### I.Төсвийн орлого

 Санхүү, төрийн сан, Татварын хэлтсийн мэдээгээр 2020 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 123.7 хувьтай буюу 9 923.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 86.1 хувьтай буюу 2 001.0 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 11 924.2 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 115.2 хувьтай байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 93 148.4 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 101.6 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 11 671.5 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 28 623.3 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 4 972.6 сая төгрөг, хандив тусламжаас 222.4 сая төгрөг, төсвөөс санхүүжих 28 181.6 сая төгрөг, аймгаас авсан татаас 9 553.8 сая төгрөг, нийт 83 225.2 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

Орон нутгийн төсвийн орлогынхоо төлөвлөгөөг Говь-Угтаал сум 8.3 хувиар буюу 50.2 сая төгрөгөөр тасалдуулсан бол бусад бүх сумд 0.4-53.7 хувиар буюу 1.8-203.2 сая төгрөгөөр төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн байна.

### II.Төсвийн зарлага

 2020 оны 12 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зардлын дүн 59 600.6 сая төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.7 хувиар өссөн байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оны мөн үеэс 15.9 хувиар өсч, 27 466.4 сая төгрөг болсон нь нийт зардлын 46.1 хувийг эзэлж байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл өмнөх оноос 14.7 хувиар өсч, 3 440.2 сая төгрөг болсон байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас 82.2 хувиар, бусад урсгал шилжүүлэг 32 хувиар, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1.1 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 30.0

хувиар, эд хогшил урсгал засварын зардал 58.2 хувиар, хангамжийн бараа материалын зардал 13.5 хувиар, норматив зардал 39 хувиар тус тус өссөн бол томилолтын зардал 35.2 хувиар, эргэж төлөгдөх зээл 23.6 хувиар, хөрөнгийн зардал 8.5 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 0.6 хувиар тус тус буурсан байна.

### **III. Банк**



Монгол банкны мэдээгээр тус аймагт нийт 34 банкны салбар нэгжид нийт 171 хүн ажиллаж байна. Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар буурч, 112 148.5 сая төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 691.6 сая төгрөг, чанаргүй зээл 1 440.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 4.3 хувиар буурч, чанаргүй зээл 13.7 хувиар өссөн байна. Нийт зээлийн үлдэгдлийн 1.9 хувийг анхаарал хандуулах ба чанаргүй зээл эзэлж байна. Нийт хадгаламжийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 36.1 хувиар өсч, 92 127.9 сая төгрөг болов.

### **IV. Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ, үнийн индекс**



Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхөөр биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2020 оны 12-р сарын байдлаар хэрэглээний үнийн индекс 2019 оны 12-р сартай харьцуулахад 4.5 хувиар өсжээ.

Хэрэглээний үнийн индекс 4.5 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 6.2 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 5.2 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлэг 8.0 хувь өссөн, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг 3.4 хувиар өссөн, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 8.3 хувь, эм тариа эмчилгээний бүлэг 6.3 хувиар өссөн, тээврийн бүлэг 3.3 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

2020 оны 12 сарын байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин, дизель түлшний үнийг орууллаа.

## ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /7 хоногоор/


№	Барааны нэр, төрөл	XII/02	XII/09	XII/16	XII/24	XII/30
1	Гурил, 1-р зэрэг, кг	1530	1650	1600	1640	1640
2	Хонины мах, кг	6000	6000	6800	6500	6800
3	Үхрийн мах, кг	0	0	0	0	0
4	Ямааны ястай мах, кг	5000	5000	5500	5500	6000
5	Элсэн чихэр, кг	2530	2530	2530	2530	2530
6	Цагаан будаа, кг	2580	2580	2580	2560	2560
7	Шингэн сүү, л	3500	3500	3500	3500	3500
8	Ноолуурын үнэ 1 кг	55000	55000	55000	55000	55000
9	Бензин А-80, 1литр	1480	1480	1480	1480	1480
10	Бензин А-92, 1литр	1540	1540	1540	1540	1540
11	Дизель түлш 1 литр	2130	2130	2130	2130	2130

### XIII.Хөдөө аж ахуй




Дундговь аймаг 2020 оны жилийн эцсийн мал тооллогын урьдчилсан дүнгээр 3 741,1 мянган толгой мал тоолуулсан нь өмнөх оноос 352 мянган толгой буюу 8.6 хувиар буурсан байна. Төрлөөр авч үзвэл тэмээ 0.9 хувиар өсч, адуу 7.0 хувь, үхэр 4.1 хувь, хонь 7.8 хувь, ямаа 11.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

## МАЛЫН ТОО, МЯНГАН ТОЛГОЙГООР



## МАЛЫН БҮТЭЦ ТАВАН ТӨРЛӨӨР

Нийт малын бүтцээр авч үзвэл 47.9 хувийг хонь, 44.5 хувийг ямаа, 4.4 хувийг адуу, 2 хувийг үхэр, 1.1 хувийг тэмээ эзэлж байна.



Аймгийн хэмжээнд 2020 оны эцэст 8593 малтай өрх байгаагийн 7248 өрх нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг малчин өрх байна. Мөн 12241 малчид байгаагаас 42.5 хувь

буюу 5210 нь эмэгтэйчүүд байна. Малтай нийт өрхийн тоо өмнөх оноос 1.0 хувиар, малчин өрхийн тоо өмнөх оноос 1.0 хувиар өссөн байна.



Аймгийн хэмжээгээр энэ оны 12 сарын байдлаар оны эхний төллөх насны хээлтэгч малын 68.9 хувь буюу 1181.5 мянган хээлтэгч мал төллөж, гарсан төл 94.8 хувь буюу 1122.8 мянган төл бойжиж байна

Аймгийн хэмжээнд 2020 оны эцэст 33.0 мянган толгой мал хорогдоод байна. Үүний 56.7 хувь нь ямаа, 36.1 хувь нь хонь, 7.2 хувийг бод малын хорогдол эзэлж байна. Нийт хорогдсон том малын 8.1 хувийг хээлтэгч мал эзэлж байна.

#### **XIV. Аж үйлдвэр**



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 13 080.9 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 25.2 хувиар өссөн байна.

I. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, 2020 оны 12 сарын байдлаар  
2021.01.10

Эдийн засгийн салбарын ангилал	Ажилд зуучилсан иргэд	үүнээс: эмэгтэй	Эдийн засгийн салбарын эзлэх хувь
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	62	18	10.8
Уул уурхай олборлох үйлдвэр	26	4	4.5
Боловсруулах аж үйлдвэр	9	3	1.6
Цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт	2	0	0.3
Усан хангамж, бохир ус, зайлуулах систем, хог	1	0	0.2
Барилга	59	9	10.3
Бөөний ба жижиглэн худалдаа	10	7	1.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	6	4	1.0
Зочид буудал, зоогийн газар	0	0	0.0
Мэдээлэл холбоо	0	0	0.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	9	7	1.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0	0	0.0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1	1	0.2
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	25	14	4.3
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	48	26	8.3
Боловсрол	42	32	7.3
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	20	14	3.5
Урлаг, үзвэр, тоглоом наадам	9	4	1.6
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	239	149	41.6
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	5	0	0.9
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	2	2	0.3
Бүгд	575	294	100.0

## II. АЙМГИЙН АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН МЭДЭЭ

2021.01.10

Сум	Оны эхний хөдөлмөрийн насны хүн ам	Тайлант сарын эхэнд байсан ажилгүйчүүд	Тайлант сарын эцэст байгаа ажилгүйчүүд	Үүнээс эмэгтэй	Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүйчүүд
Дэлгэрцогт	1178	0	18	8	153
Дэрэн	1474	16	19	8	129
Говь-Угтаал	1106	1	53	28	479
Цагаандэлгэр	723	3	9	2	124
Баянжаргалан	858	10	16	5	186
Өндөршил	1027	4	16	6	156
Гурвансайхан	1560	0	26	6	167
Өлзийт	1712	0	1	0	6
Хулд	1697	14	53	28	312
Луус	1331	4	7	0	53
Дэлгэрхангай	1581	12	39	22	247
Сайхан-Овоо	1508	1	18	12	119
Эрдэнэдалай	3954	12	41	25	104
Сайнцагаан	10649	89	185	91	174
Адаацаг	1958	1	23	11	117
Дүн	32316	167	524	252	162

### III.НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН МЭДЭЭ, 2020 оны 12 сарын байдлаар мян.төг

20210110

Халамжийн төрөл	Хамрагдсан хүн	Мөнгөн дүн
<b>Нийгмийн халамжийн тэтгэвэр</b>	<b>837</b>	<b>2542058.1</b>
Ахмад настны тэтгэвэр	54	144005.2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	556	1598139.4
Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд	227	799913.5
<b>Нийгмийн халамжийн тэтгэмж</b>	<b>2242</b>	<b>1827699.6</b>
<i>Асаргааны тэтгэмж</i>	<b>1227</b>	<b>1099836.0</b>
<i>Бүтэн өнчин хүүхдийг үрчилж авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэний</i>	31	33910.3
<i>Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэний</i>	6	7547.8
<i>Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэний мөр(52)=мөр(53+54)</i>	<b>3</b>	<b>3016.5</b>
<i>Ахмад настныг гэртээ асрамжилж байгаа иргэний</i>	3	3017.0
<i>Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэний мөр(55)=мөр(56+57+58)</i>	<b>1187</b>	<b>1055361.8</b>
<i>Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа</i>	218	181059.2
<i>Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэний</i>	788	630368.4
<i>Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа</i>	181	243934.3
<i>Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай өрхийн гишүүн-иргэний тэтгэмж</i>		
<b>Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж</b>	<b>1015</b>	<b>727863.6</b>
<i>Гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх</i>	50	60000.0
<i>18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн</i>	2	2400.0
<i>Хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн</i>	6	7200.0
<i>Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхэд</i>	185	505003.6
<i>Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн</i>	772	153260.0
<b>Алдарт эхийн одонгийн мөнгөн тусламж</b>	<b>4622</b>	<b>616700.0</b>
<b>Нийгмийн халамжийн үйлчилгээ</b>	<b>55</b>	<b>21301.5</b>
<b>Нийгмийн хөгжлийн үйлчилгээ</b>	<b>2996</b>	<b>682336.0</b>
<i>Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ</i>	2996	682336.0
<b>Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт</b>	<b>1897</b>	<b>390972.7</b>
<b>Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт</b>	<b>27</b>	<b>52155.9</b>
<b>Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт</b>	<b>627</b>	<b>135254.3</b>
<b>Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж</b>	<b>4085</b>	<b>299128.9</b>
<i>0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж</i>	2761	110761.1
<i>Жирэмсэн эхийн тэтгэмж</i>	1167	17235.7
<i>Ихэр хүүхдийн тэтгэмж</i>	7	14000.0
<i>Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж</i>	<b>150</b>	<b>157132.0</b>
<b>Насны хишиг</b>	<b>2634</b>	<b>459410.0</b>
<b>Нийт</b>	<b>20022</b>	<b>7027017.0</b>

#### IV. НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сумд	Бүтэн өнчин хүүхэд		Хагас өнчин хүүхэд		Хөгжлийн бэрхшээлтэй хүн		18 хүртлэх насны 4 түүнээс дээш хүүхэдтэй өрх		2021.01.10 18 хүртлэх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эх	
	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020
	Дэлгэрцогт	2	1	20	24	71	65	26	23	39
Дэрэн	1	1	14	19	71	66	42	43	27	29
Говь-Угтаал	1	1	26	25	83	89	14	19	29	37
Цагаандэлгэр	0	0	20	19	25	32	17	21	36	34
Баянжаргалан	1	1	15	14	25	31	18	18	27	21
Өндөршил	0	1	17	35	41	38	10	12	29	24
Гурвансайхан	0	0	16	13	62	68	32	38	23	25
Өлзийт	3	3	18	15	89	91	29	34	59	56
Хулд	2	2	22	23	72	65	19	19	50	48
Луус	2	2	18	15	111	99	25	20	62	62
Дэлгэрхангай	0	0	42	35	116	122	24	37	53	60
Сайхан-Овоо	2	2	11	9	64	67	56	51	52	41
Эрдэнэдалай	4	3	57	73	188	198	91	110	109	91
Сайнцагаан	13	13	123	131	729	731	140	175	354	352
Адаацаг	4	3	34	27	117	104	36	34	59	51
Бүгд	35	33	453	477	1864	1866	579	654	1008	972

## V.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, ТЭТГЭВЭРИЙН САНХҮҮЖИЛТ

2021.01.10

мян.төг

Сумд	Н.Д.Шимтгэлийн орлого			Тэтгэвэрийн санхүүжилт		
	төл	гүйц	хувь	олгох	олгосон	хувь
Дэлгэрцогт	321342.6	324791.1	101.1	1442985.6	1442985.6	100.0
Дэрэн	313916.9	317775.3	101.2	1564004.1	1564004.1	100.0
Говь-Угтаал	385322.0	392400.4	101.8	1293507.4	1293507.4	100.0
Цагаандэлгэр	232473.9	239127.8	102.9	717827.5	717827.5	100.0
Баянжаргалан	320316.8	324625.7	101.3	793042.5	793042.5	100.0
Өндөршил	300836.7	308425.8	102.5	1014785.6	1014785.6	100.0
Гурвансайхан	380122.6	385359.1	101.4	1336343.4	1336343.4	100.0
Өлзийт	425563.5	447509.6	105.2	1773005.9	1773005.9	100.0
Хулд	410177.1	420320.5	102.5	1688548.9	1688548.9	100.0
Луус	321219.4	331419.4	103.2	1418778.1	1418778.1	100.0
Дэлгэрхангай	410825.2	413337.5	100.6	1638813.7	1638813.7	100.0
Сайхан-Овоо	320848.5	327317.4	102.0	1325132.7	1325132.7	100.0
Эрдэнэдалай	815236.2	827335.9	101.5	4219598.9	4219598.9	100.0
Адаацаг	401452.2	404535.3	100.8	1800070.5	1800070.5	100.0
Сайнцагаан	6495393.5	6574379.8	101.2	12955650.6	12955650.6	100.0
Дүн	11855047.1	12038660.6	101.5	34982095.4	34982095.4	100.0

VI.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОРЛОГО, ЗАРЛАГА/сая.төг/

2021.01.10

	2019 оны XII сар	2020 оны XII сар			<u>2020 XII</u> 2019 XII хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Нийгмийн даатгалын сангийн орлого	34856.3	11855.0	43165.2	364.1	123.8
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	30157.3	10293.7	37624.2	365.5	124.8
Тэтгэмжийн даатгалын сангийн	1460.9	853.2	1791.4	210.0	122.6
Эрүүл мэндийн даатгалын сангийн	2237.1	0.0	2620.1	0.0	117.1
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	689.2	546.0	725.6	132.9	105.3
Ажилгүйдлийн даатгалын сангийн	311.8	162.1	403.9	249.2	129.5
Нийгмийн даатгалын сангийн зарлага	34073.0	38032.3	40505.8	106.5	118.9
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	29431.3	35820.8	35030.4	97.8	119.0
Тэтгэмжийн даатгалын сангийн	1395.7	1606.1	1741.3	108.4	124.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн	2237.6	0.0	2619.7	0.0	117.1
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	688.9	164.6	720.1	437.5	104.5
Ажилгүйдлийн даатгалын сангийн	319.5	440.8	394.3	89.5	123.4

Тайлбар: \*Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал

VII. НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧИЙН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭРИЙН ХЭМЖЭЭ

2021.01.10

Үзүүлэлтүүд	2018 оны XII сар	2019 оны XII сар	2020 оны XII сар	<u>2020 XII</u> <u>2019 XII</u> хувь
Заавал даатгуулагчийн тоо	11231	11224	11920	106.2
Үүнээс				
Аж ахуй нэгж, байгууллага	2503	2477	2396	96.7
Төсөвт байгууллага	4284	4258	4199	98.6
Сайн дурын	4444	4489	5325	118.6
Олгосон тэтгэвэр, сая,төг	25821.0	29424.8	34885.8	118.6
Үүнээс				
Өндөр настны	21386.3	24590.7	29466.3	119.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	2892.4	3078.2	3411.7	110.8
Тэжээгчээ алдсаны	722.9	796.5	914.1	114.8
Цэргийн	819.4	959.4	1093.7	114.0

## VIII. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ сумдаар

2021.01.10

сумд	төрсөн хүүхдийн тоо		Бүх нас баралт		0-1 насны хүүхдийн эндэгдэл		0-5 насны хүүхдийн эндэгдэл	
	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020
Дэлгэрцогт	2	1	13	12	0	0	1	0
Дэрэн	5	4	8	12	0	0	0	0
Говь-Угтаал	22	13	7	6	0	0	0	0
Цагаандэлгэр	2	2	3	3	0	0	0	0
Баянжаргалан	2	3	9	6	0	0	0	0
Өндөршил	3	6	8	3	0	0	0	0
Гурвансайхан	1	1	11	16	0	0	0	0
Өлзийт	10	10	9	2	0	0	0	0
Хулд	1	2	8	15	0	0	0	0
Луус	3	0	10	8	0	0	0	0
Дэлгэрхангай	17	14	18	11	0	1	0	1
Сайхан-Овоо	5	2	13	11	0	0	0	1
Эрдэнэдалай	27	22	36	30	2	0	2	0
Сайнцагаан	845	809	81	75	1	5	1	6
Адаацаг	7	7	16	10	1	1	2	1
Дүн	952	896	250	220	4	7	6	9

\* Эрүүл мэндийн газрын мэдээгээр

IX. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 12 сарын байдлаар

2021.01.10

Сумд	Хэвтэж эмчлүүлсэн хүний тоо		Бүгд үзлэг		Бүртгэгдсэн бүх өвчлөл		Халдварт өвчин бүгд		үүнээс /зарим үзүүлэлтээр/			
									сүрьеэ		салхинцэцэг	
	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020
Дц	313	281	1969	1904	317	302	13	7	0	1	1	0
Дн	172	160	1706	2421	457	441	6	11	1	1	0	1
Гу	253	193	3815	3687	1976	1974	18	15	1	0	11	7
Цд	167	120	1254	1592	269	814	2	6	0	0	0	5
Бж	232	116	2160	1905	239	184	1	8	0	0	1	1
Өш	292	278	3119	3583	362	445	0	6	0	0	0	0
Гс	155	93	3386	3768	599	185	14	11	1	0	5	2
Өт	137	150	3289	3387	316	286	22	7	2	2	1	0
Хд	199	153	1376	1075	690	531	13	8	2	2	1	0
Лс	232	148	3914	2808	203	234	5	11	1	0	2	2
Дх	183	145	2032	2470	101	95	7	5	1	1	0	0
Со	183	153	977	1031	464	477	2	4	0	0	0	0
Эд	525	633	11262	10408	2334	2312	20	28	4	2	5	1
Ад	319	247	3479	3561	419	389	13	12	4	4	6	0
Сц	5699	5464	130999	137100	24596	25439	271	169	12	13	143	18
Мд	450	431	403	401	0	0	0	0	0	0	0	0
Эб	419	400	450	472	0	0	0	0	0	0	0	0
МУЭ төв	934	896	2056	2293	684	591	0	0	0	0	0	0
ДҮН	10864	10061	177646	183866	34026	34699	407	308	29	26	176	37

\* Эрүүл мэндийн газрын мэдээгээр

## Х.Боловсролын байгууллагын зарим үзүүлэлтүүд 2020-2021 оны хичээлийн жил

Сумдын нэр	ЕБС-д суралцагсад	үүнээс		Бүх багш нар	үүнээс		Нэг багшид ногдох суралцагсдын тоо	1-5 ангийн нэг багшид ногдох суралцагсдын тоо	6-11 р ангийн нэг багшид ногдох суралцагсдын тоо	12-р анги төгсөгчид	9-р анги төгсөгчид/12/	1-р ангид элсэгчид	Дотуур байранд суудаг хүүхдийн тоо	12-р ангид элсэгчид	9-р ангид элсэгчид
		1-5 р ангид	6-12 р ангид		бага ангийн багш	дунд, ахлах ангийн багш									
Дэлгэрцогт	153	101	52	15	5	10	10.2	20.2	5.2	0	12	24	45	0	13
Дэрэн	257	138	119	18	6	12	14.3	23.0	9.9	0	23	41	46	0	26
Говь-Угтаал	171	98	73	14	5	9	12.2	19.6	8.1	0	15	22	20	0	12
Цагаандэлгэр	92	61	31	12	5	7	7.7	12.2	4.4	0	12	14	11	0	8
Баянжаргалан	180	110	70	13	5	8	13.8	22.0	8.8	0	15	25	63	0	8
Өндөршил	205	123	82	14	5	9	14.6	24.6	9.1	0	19	25	36	0	20
Гурвансайхан	310	128	182	20	5	15	15.5	25.6	12.1	20	26	25	63	22	24
Өлзийт	160	102	58	14	5	9	11.4	20.4	6.4	0	5	22	38	0	5
Хулд	216	126	90	20	8	12	10.8	15.8	7.5	0	13	26	13	0	19
Луус	141	79	62	14	4	10	10.1	19.8	6.2	0	17	20	43	0	14
Дэлгэрхангай	413	187	226	34	12	22	12.1	15.6	10.3	34	43	40	25	25	33
Сайхан-Овоо	239	132	107	16	5	11	14.9	26.4	9.7	0	27	22	48	0	17
